

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



БАТДАВ
Э.АНХБАЯР

2020 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн
51 дүгээр тогтоолын 7 дүгээр хавсралт

**ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЫН МАЯГТ**

1. Түрээслэх эд хөрөнгийн танилцуулга

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн автомашины төлбөртэй зогсоолыг түрээслэн ажиллуулах түрээслэгчийн сонгон шалгаруулалт зарлаж байна. Нийт 150 автомашины 900 м2 хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах гадна талбайг ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН 49-р тогтоолын хавсралт дахь 1мкв нь 10.000 /арван мянга/ төгрөгөөр авто зогсоолыг түрээслүүлнэ.

2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2025 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 00 минут
Материал хүлээн авах хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо Халдварт өвчин судлалын үндэсний төв захиргааны байр 2 давхарт 206 тоот.
Материал нээх хугацаа, хаяг байршил	Халдварт өвчин судлалын үндэсний төв захиргааны байр 2 давхарт 213 тоот 2025 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	Автомашины нэг зогсоол нийт 150 автомашины 900 м2 хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах гадна талбай түрээсийн доод үнийг 9,000,000 /есөн сая/ төгрөг болно. Автомашины дугаар уншигч бүхий бүрэн авомат авто зогсоолын хаалтыг төв үүд болон хойд хаалганы орц, гарцанд байршуулж суурилуулах засвар үйлчилгээ хийх үнийн саналын хамт ирүүлнэ.
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай	Шаардлагатай. Төвийн төлбөртэй зогсоолын дагаж мөрдөх журманд нийцүүлэн бичиг баримтыг бүрдүүлэх.

зөвшөөрлийн мэдээлэл	
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гэдгээ оролцогч өөрөө нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ. Дутуу тохиолдолд үл маргах журмаар хасна.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	<ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээг баталгаажуулан хуулбарлан ирүүлэх 2. Түрээсээр эзэмших ашигтай талбай болон нийтийн эзэмшлийн талбайд явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (тухайн чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, ижил төстэй ажлын гэрээний хуулбар) ирүүлэх; 3. Санхүүгийн чадварыг нотлох баримт: 2022, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын цахим тодорхойлолт; 4. Ажиллах хүчний мэдээлэл; Тухайн түрээслэж буй талбайн цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцах тухай тодорхойлолт; 5. Түрээслэх үнийн санал; 6. Авто зогсоолын хаалт суурилуулах талаар мэдээлэл, танилцуулга, зогсоолын хаалтын техникийн тодорхойлолт; 7. Сонгон шалгаруулалтад оролцох хураамж 50,000 төгрөг /тавин мянган/ тушаасан баримт;

3. Нэмэлт шаардлага:

1. 1 дүгээр пост:
 - ✓ Төв үүдний хэсгийн хэсэгчлэсэн засварын ажил хийж гүйцэтгэх /Аюулгүй гарцын төмөр хашаг буулгах, зөөвөрлөх үлдсэн хэсэгт засвар хийх/
 - ✓ Тэмдэг тэмдэглэгээ нэмэлтээр хийх.
2. 2 дугаар пост:
 - ✓ Шинээр пост бий болгох.
 - ✓ Тухайн цэгт ажиллах ажилтанд аюулгүй ажиллагаа, тохь тухтай байдлыг хангах.
 - ✓ Автомашины дугаар уншигч бүхий бүрэн авомат авто зогсоолын хаалтыг орц, гарцанд байршуулж суурилуулах засвар үйлчилгээ хийх.
3. Яаралтай болон тусгай тээврийн хэрэгсэл, ажилчдын автомашин үнэ төлбөргүй;
4. Талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, зохион байгуулалтын ажил хариуцах;
5. Гамшгийн ослын үеийн бэлэн байдал болон ХӨСҮТ-өөс зохион байгуулсан ажил арга хэмжээнд талбай чөлөөлөхийг хариуцах;

6. Онгоц буухад талбайн бэлэн байдлыг хариуцах;

Материалыг зарласан хугацаанд, байгууллагын нэр, өөрийн аж ахуй нэгжийн нэр, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд бичиж битүүмжилсэн хэлбэрээр ирүүлнэ үү.

4. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр ирж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг ажлын цагаар 91090603, 99992294 дугаарын утсаар болон www.nccd.gov.mn цахим хуудаснаас авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо өөрийн байр